

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР
САРЫН 10-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-7
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	8-69
	1.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	12-22
	2.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	22-45
	3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	45-56
	4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	56-59
	5.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	59-64
	6.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	64-67
	7.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/	67-68
	8.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	68-69

ХУРАЛДААНЫ ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Гурав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч С.Орхон, Б.Гэрэлсайхан, ахлах мэргэжилтэн Ө.Бодьгэрэл, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баяртуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Саранчимэг, Ц.Туваан, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын

бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

П.Анужин: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 1 сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Хуулийн төслийн танилцуулгыг ХНХ-ын сайд Төмөрбаатарын Аюурсайхан танилцуулна.

Т.Аюурсайхан: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжүүлснээс хойш тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, сангийн чадавхыг бэхжүүлэх, тэтгэврийн нас, шимтгэл төлсөн хугацааг үе шаттайгаар өсгөх, үнэ, ханшийн өсөлт, амьжиргааны өртөгтэй уялдуулан

тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, хүүхдийн асран хугацаанд эхчүүдийн шимтгэл төлөлт тасрахгүй байх зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Тэтгэврийн даатгалын сангаас 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 474.3 мянган тэтгэвэр авагчид 2.8 их наяд төгрөг зарцуулаад байна. Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо нийт тэтгэвэр авагчдын 78.2 хувь буюу 371000-д хүрсэн. Түүнчлэн 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2020 онд 4 байгаа бөгөөд 2025 оноос эхлэн хүн ам зүйн цонх үе хаагдаж, дундаж наслалт нэмэгдсэнээр нийт хүн амд эзлэх тэтгэвэр авагчийн тоо өсөж, 2030 онд 7, цаашид 2050 онд 9 тэтгэвэр авагч болохоор байна.

Хүн амын дундаж наслалт 2021 онд 71 жил болж 26 жилийн өмнө буюу нийгмийн даатгалын хуулийг анх батлах үеийн дундаж наслалтын түвшинтэй харьцуулахад 7.3 жилээр өссөн. Тухайлбал эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.1 болж 6 жилээр, эмэгтэйчүүдийнх 76.5 жил болж, 11 жилээр тус тус өссөн байна.

Тэтгэврийн насны хүн 2021 онд нийт хүн амын 10 хувийг эзэлж байсан бол 2030 онд 13.4, 2050 онд 19.4 хувьд хүрэхээр байна. Ирээдүйд бий болох хүн амын насжилт, тэтгэвэр авагчийн тооны өсөлт нь цаашид тэтгэврийн даатгалын сангийн зардал улсын төсвийн ачааллыг улам нэмэгдүүлэхээр байгаа тул хуулийн шинэчлэлийг зайлшгүй хийх шаардлагатай байна.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн тав дахь хэсэгт өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй гэж заасан байдаг. Түүнчлэн Монгол УИХ-ын тогтоолоор батлагдсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийх, хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлнэ гэж тус тус заасан.

Иймд дээрх үндэслэл, шаардлагад нийцүүлэн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн насыг жил бүр 3 сар нэмэгдүүлж буйг хэвээр үргэлжлүүлэх, тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох аргачлалд өөрчлөлт оруулж илүү олон жил шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэвэр тогтоолгох дараалсан 7 жилийг 5 жил болгож бууруулах, нас барсан тэтгэвэр авагчийн эхнэр эсвэл нөхрийнх нь өндөр насны тэтгэврийн хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлдэг болох, хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр цаашид тэтгэвэр тогтоохгүй байх зэрэг бусад зохицуулалтуудыг тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар Тэтгэврийн даатгалын сан урт хугацаанд тогтвортой ажиллах, хувийн нэмэлт тэтгэврийн эрх зүйн орчин бүрдэж ахмад настан олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжтой болох, төлсөн шимтгэлтэйгээ уялдсан тэтгэвэр тогтоох аргачлал нэвтрэх, хууль хоорондын зөрчил арилж, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах зэрэг эерэг үр дагаврууд бий болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан 22 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд болон иргэн төрийн байгууллагад нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд одоо байгаа нийгмийн даатгалын тогтолцооны хүрээнд нэмж хүний нөөц шаардахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой юм.

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Аюурсайхан сайдад баярлалаа.

Түрүүн санал, дүгнэлтийг УИХ-д танилцуулах гишүүнийг томилоогүй үлдээсэн байгаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг ерөнхий хуулийн шүү, тийм ээ, ерөнхий хуулийн Байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр УИХ-ын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийг томилж байна.

2 дугаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Түрүүн уг яг энэ тэтгэвэртэй холбоотойгоор гишүүд маш их асуулт асуусан байгаа. Тэгэхээр энэ ахиад явж байна гэдгийг бас анхаарч үзэж асуултаа бас давхардуулахгүй. Тийм ээ, түрүүн бас асуугдаагүй асуултуудыг асуухыг бас гишүүддээ хүсэж байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Дэмжиж байгаа. Энэ хамгийн их хүлээлт үүсгэж байгаа асуудал байгаа. Хамгийн гол нь манай ахмадуудын ганц хүсэж байгаа юм миний тэтгэвэр инфляцтай уялдаад хэзээ нэмэгдэх юм бэ? Өнөөдөр яг үнэнийг хэлэхэд энэ гадаад дотоод нөхцөл байдал, хил гааль, хаалттай байсан, ковидын нөхцөл байдлаас болоод хамгийн их хямарч байгаа хүмүүс маань ахмадууд байгаа. Сая бас хэлж байна л даа. Тэр зээлийг л аваад үзэхэд 197000 ахмадууд буюу 488 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлтэй байна гэдэг чинь 40 орчим хувь нь болчихсон байна шүү дээ. Тэгээд тэтгэврийн зээл нь ингээд л төлөгдөж чадахгүй яваад байдаг. Үнэхээр асуудал байгаа. Тойрогтоо очоод уулзалт хийх болгонд ахмадууд маань үнэхээр амьдрахад хэцүү боллоо. Тэтгэврээ 2 хувааж авдаг 7 хоногийн дотор дуусаад дараагийн авах хүртэл өлөн зэлмэн байна гээд бид нарт ингээд босоод хэлж байсан. Тэгээд ингээд бас 24 оны 1 сарын 1-нээс эхлээд инфляцтай уялдуулж индексжүүлсэн байдлаар нэмэх асуудал ингээд орж ирж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дээр яг ямар бодлого барьж, тооцоо судалгааг яаж хийж байгаа вэ? Өмнө нь жишээлбэл нэг 12-16 онд жишээлбэл 20 төгрөгөөр нэмэгдсэн. Энэ хүмүүсийн бухимдал төрүүлж байсан. Сая бид нар 18 онд нөгөө доод босгыг 500000 төгрөг болгосон шүү дээ. Үүнийг би маш зөв гэж бодож байгаа. Үүнийг манай Нийгмийн бодлогын байнгын хороо, тухайн үеийн ХНХ-ын сайд, засгийн Ерөнхий сайд, Монгол Улсын Ерөнхийлөгч хүртэл ингэж бүгдийг нь суулгаж байгаад яаралтай энэ асуудлаа шийд гэж байсан. Түүн дээр тэгээд Нийгмийн бодлогын байнгын хороо ч маш идэвхтэй оролцоод би доод босгыг 500 болгосон. Гэтэл үүнийг бас зарим салбарын яамны хүмүүс маань эртээд Амартүвшин гишүүн тэр маш буруу юм хийсэн. Энэ попрот энэ тэр гэж хэлж байна лээ. Ийм зүйл биш шүү дээ. Харин ч энэ 500 болгоогүй энэ 300000 төгрөгөөр яаж амьдрах байсан бэ гэдэг бүр үнэхээр ноцтой асуудал шүү дээ. Харин ч бид тодорхой ингээд

шатлалтайгаар эхний хэсгээ доод босгыг нь 500 болголоо. Одоо харин бас улс орондоо үнэхээр мундаг сайн ажиллаж байсан сэхээтнүүд маань эмч, багш нар маань бусад хүмүүсийнхээ тэтгэврийн босгыг бас нэмэх шаардлагатай байгааг нөгөө Нийгмийн бодлогын байнгын хорооноос нэг ахмадуудын уулзалт зохион байгуулахад бүгд босоод хэлж байсан л даа. Ахмадууд маань ядуурлын арми руу нэгдэхэд их ойрхон болж байна. Тэгэхдээ энд нөгөө энэ ковид, гадаад дотоод эдийн засгийн нөхцөл байдал голлож нөлөөлсөн талаар бас судалгаатай маш нарийн мэдээллүүд бидэнд өгч байсан. Тэгэхээр ингээд орж ирж байна.

Тэгээд эндээс гол хүлээж байгаа нь л урт хугацаанд тэтгэврийн тогтолцоо ингээд найдвартай яваасай. Миний тэтгэвэр инфляцтай уялдаад ингээд хөдөлдөг байгаасай, өсвөл өсдөг, буурвал тэр нь тэгээд зохицуулагдаад явдаг байгаасай гэж хүсэж байгаа. Тэгэхдээ энэ дээр яг түрүүн би эдийн засгийн судалгааг нь асуулаа. 1 дэх асуулт.

2 дахь асуулт нь энэ нөгөө бид нар хуваарилалтаас хуримтлал руу явах хагас хуримтлал руу орох тухай ярьж байна. Зүгээр дэлхийн жишгийг аваад үзэхэд өнөөдөр хамгийн сайн ажиллаж байгаа тэтгэврийн тогтолцоо бол энэ хуваарилалтын систем байгаа. Тэгээд манай нам жишээлбэл социал демократ гээд зарласан. Тийм ээ. Тэгээд энэ хуваарилалт дээр илүү тогтвортой явах юм байна. Харин хувь хүн сайн дураараа хуримтлал үүсгээд ингээд явчих нөөц санг бас бүрдүүлээд явах юм байна л даа. Ер нь зүгээр та нар сайн тооцоо судалгаа хийсэн үү? Яг өнөөгийн нөхцөл байдалд хуваарилалт маань илүү манай энэ систем дээр ажиллаад явах юм уу эсвэл бид хуримтлал руу ер нь цаг алдалгүй орчих нь зөв гэсэн байр суурьтай байгаа юм уу? Энэ дээр цаад охин маань саналаа хэлнэ үү? Баярлалаа.

П.Анужин: Оюунчимэг гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулна.

Т.Аюурсайхан: Хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр энэ тэтгэврийг жил болгон үнийн өсөлтийн түвшинтэй уялдуулж нэмэгдүүлж байхаар заасан байгаа. Тэгэхээр хэдээр нэмэгдүүлэх вэ гэдэг нь нөгөө инфляцын түвшинтэй уялдаад тогтоогдоно гэсэн үг. Жил болгон итгэлцүүрээ шинэчлээд ингээд тэтгэврийн нэмэгдлийг хийгээд явах юм бол энэ цаашид тэтгэврийн зөрүү гаргахгүй байх энэ нөхцөлийг нь бүрдүүлнэ.

Энэ хуулиа хэрэгжүүлэхийн өмнө одоо үүсээд байгаа зөрүүгээ арилгаж цэгцэлж байгаад хуулиа хэрэгжүүлэхгүй энэ бас цаашдаа гажуудал бас гүнзгийрээд үргэлжлээд явах ийм эрсдэлтэй байгаа юм. Тэгэхээр яах вэ, бид нарын хийсэн тооцоогоор болбол таны хэлсэн тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлсэн. Энэ 2022 оны төсвийн тодотголоор авсан арга хэмжээ зайлшгүй хийх ёстой асуудал байсан. Үүний дараа юу хийх ёстой вэ гэх юм бол энд үүсээд байгаа дундаж тэтгэврийн түвшин авч байсан ахмадуудаас тэтгэврийн доод хэмжээ рүү бас шилжсэн ийм асуудлууд байгаа. Энэ тооцоог нь хийгээд энэ хүмүүсийг эргээд тэтгэврийнх нь энэ тодорхой хэмжээний алдааг залруулах юм бол нэг 50 орчим тэрбум төгрөг хамгийн эхэнд шаардлагатай байгаа. Ингээд нийтдээ энэ дээр нэмэгдүүлээд одоогийн байдлаар энэ үүссэн зөрүүг арилгах юм бол 152 орчим тэрбум төгрөг шаардлагатай байгаа. Тэтгэврийн зөрүүгээ энэ төсвийн нөөц боломжтойгоо уялдуулаад энэ арга хэмжээгээ авсны үндсэн дээр ингээд хууль батлагдах юм бол жил болгон итгэлцүүрээ шинэчлээд, жил болгон үнийн өсөлтөө тооцоолоод тэтгэврээ нэмээд явчих юм бол ингээд өмнө яригдаад байдаг байсан энэ зөрүү үүсгэхгүйгээр явах юм гэж тооцоолж байгаа.

Хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоо руу явах шаардлагатай. Хуваарилалтын буюу энэ санааны тогтолцооноос олон дэлхийн олон улс орнууд одоо татгалзаад хуримтлалын тогтолцоо зарим улс орнууд бүрэн хуримтлалын тогтолцоо руу шилжчихсэн ингээд явж байгаа. Энэ бол их олон төрлийн ач холбогдолтой.

1 дүгээрт, энэ хүн хэдэн жил ажиллаж, хэчнээн хэмжээний шимтгэл төлж байсантайгаа уялдуулаад тэтгэвэр нь тогтоогддог байх ийм нөхцөл байдал үүснэ. Одоогийн байгаа 5 жил үү, 7 жилийн дундаж уу. Мөн түүнчлэн сайн дурын тэтгэвэр даатгал төлж байгаа бас багагүй тооны иргэд байна. Эдгээр хүмүүс бол бага хэмжээгээр тэтгэврийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлж байгаад сүүлийн 5 жил маш өндөр үүнийг 10 дахин үржүүлсэн хэмжээгээр төлөөд ингээд зүй бусаар хэт өндөр тэтгэвэр тогтоолгоод энэ нь нийт тэтгэврийн сан дээр ачаалал үүсдэг. Гэх мэтчилний маш энэ хуримтлалын тогтолцоо, хуваарилалтын тогтолцоо чинь маш олон бас хажуу нөхцөлүүд байгаа. Тийм учраас хуримтлалын тогтолцоонд шилжих нь зөв. Энэ мэдээж төсвийн нөөц боломжоор бид нар бүрэн хуримтлалын тогтолцоонд 2044 онд шилжинэ гэж тооцож байгаа. Тэр болтол мэдээж энэ төсвөө ачааллаасаа болоод үе шаттайгаар шилжих нь зүйтэй юм. Тэгэхээр энэ хуримтлалын тогтолцоо нь олон ач холбогдолтой тэтгэвэр нь өвлөгддөг байх боломжтой болно. Тодорхой хэмжээнд. Мөн түүнчлэн энэ хуримтлалын сантайгаа уялдуулаад тэтгэврээ одоо орон сууцны дэмжлэгээр, боловсролын үйлчилгээгээр, эрүүл мэндийн үйлчилгээгээр авдаг болох энэ тогтолцоо нь яг юу олгох вэ, боломжийг юу олгох вэ гэхээр энэ хуримтлалын тогтолцоо олгох юм.

П.Анужин: Батсүхийн Саранчимэг гишүүн асуулт асууя.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр нийгмийн даатгалын багц хуулийн төслийн хүрээнд энэ нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг бид нар хэлэлцэж байна. Тэгэхээр энэ хуулийн төсөл нийгэмд үнэхээр их хүлээлт үүсгэчихсэн байгаа. Тэгэхээр эндээс бас нэг тодруулж асуух зүйлүүд байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн сан сүүлийн жилүүдэд янз бүрийн нөхцөл шалтгаанаас болоод яах аргагүй ингээд алдагдалтай гараад байгаа. Тэгээд Монголын хүн амын насжилт, дээрээс нь дундаж наслалт өсөж байгаа зэрэг нь энэ Тэтгэврийн даатгалын санд ирэх ачааллыг улам ч нэмэгдүүлж байгаа юм. Тэгэхээр энэ нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийг шинэчилснээр энэ сангийн алдагдал буурах уу. Хэдий хэмжээгээр буурах төсөөлөлтэй байгаа вэ. Ямар нэгэн судалгаа тооцоо хийсэн байна уу?

Одоогийн хуулиар өндөр насны тэтгэврийг дараалсан 7 жилийн дунджаар ингэж тогтоож байгаа. Зарим гишүүн бас ингээд 5 жилээр тооцох ингээд төсөл өргөн барьчихсан байгаа. Ер нь аливаа ингээд шинэчлэл хийнэ ээ гэдэг бол сайжруулж боловсронгуй болгох л учиртай учраас энэ хууль өргөн баригдсанаараа тэтгэвэрт тооцон тогтоох талаар хууль санаачлагчдаас илүү тодорхой бас нэг хариултыг авмаар байна.

Хуулийн төслийн энэ 27.1-д тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ гэсэн ийм заалт оруулсан байна. Тэгэхээр энэ 27.1 дэх хэсэг хууль хүчин хүчин төгөлдөр болсноос эхлэн хэрэгжиж эхлэх үү. Эдийн

засгийн өсөлт, инфляцын түвшин бага үед асуудалгүй ч гэлээ энэ хямралтын үе инфляц өндөр байгаа үед энэ төсөвт хэдий хэмжээний нэмэлт зардал гарахаар ингэж тооцсон байгаа вэ? Энэ дээр нэг тайлбар авъя. Баярлалаа.

П.Анужин: 2 номерын микрофонд Өнөрбаяр дарга хариулна.

Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Өнөрбаяр. Нийгмийн даатгалын сан бол ерөнхийдөө хүмүүс юу гэж ойлгодог вэ гэхээр их алдагдалтай юм шиг ойлгоод байдаг. Уг нь нийгмийн даатгалын санд улс өөрөө ингээд хий бичилтүүдийнхээ мөнгийг өгөөд ингээд явбал менежментээ өөрөө хийгээд явсан тохиолдолд энэ тийм алдагдалтай сан биш ээ гэдгийг 1 дүгээрт хэлэх ёстой.

Энэ жил гэхэд өөрөөр хэлбэл улсын төсвөөс нийгмийн даатгалын санд ямар нэгэн татаас өгөөгүй, нийгмийн даатгалын сан өөрөө өөрийгөө хариуцаад ахмадуудынхаа тэтгэврийг тавиад явж байгаа. Улсын төсвөөс 545 тэрбум төгрөг тавигдсан. Энэ юуны мөнгө вэ гэхээр 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоогдсон хүмүүсийн мөнгө болон цэргийн албан хаагчдын тэтгэврийн мөнгө л манай сан дээр тавигдсан. Тэгэхээр энэ жил сан өөрөө өөрийнхөө өөрөөр хэлбэл зардлыг хариуцаад явж байгаа гэдгийг хэлье.

Цаашид бид нар ирэх жил хэрвээ энэ хууль ингээд батлагдаад явбал улсын төсөв дээр ямар асуудал ирэх вэ гэхээр 2 л асуудал яригдана. 1 дүгээрт нь бол тэтгэврийн нөөц сан руу нэг, нэг хувийг буюу 2 хувийг хуримтлуулсан тохиолдолд 291 орчим тэрбум төгрөгийн асуудал нэг яригдана. Улсын төсөв дээр.

Нөгөөдөх нь тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулаад нэмэгдүүлэх гэдэг тэтгэврийн зөрүү арилгах гэсэн ийм тооцоолол л яригдана. Өөр бусад асуудал бас яригдахгүй ээ гэдгийг хэлье. Тэтгэврийн даатгалын сан, нийгмийн даатгалын сан бусад асуудлуудаа өөрсдөө зохицуулалт хийгээд явчихна.

П.Анужин: Саранчимэг гишүүний асуусан асуултад Аюурсайхан сайд нэмэлт нэмж хариулна. 7, 5 жилийн тооцооллын тал дээр.

Т.Аюурсайхан: Яах вэ 5 жилийг 7 жил болгох энэ үндэслэлүүдийг би бас тэр Дэлхийн банкны хийсэн судалгааг харсан юм. Энэ сан дээр бол улсын төсвийн ачаалал бас татаас их нэмэгдэхээр байна. Тухайлбал, 2019 онд төсвийн орлогын 9.2 хувиар татаас олгохоор байна. Ингээд энэ төсвийн орлогоос олгох татаас нь төсвийн орлогын 2050 онд 37 хувь болж өсөхөөр байна гэсэн ийм тооцооллуудын үндэслэл байсан юм байна лээ.

Сая Өнөрбаяр дарга хэллээ. Жишээлбэл нийгмийн даатгалын сан 2020 онд ашигтай гарсан. Татаас ч юу байх вэ 95 оноос өмнө тэтгэвэр гарсан хүмүүсийн тэтгэвэр, дээр нь цэргийн албан хаагчдын тэтгэвэрт улсын төсвөөс 950 орчим тэрбум төгрөг тавигдаж байсан бол 22 онд энэ нь буураад 540 орчим тэрбум төгрөг тавигдаж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл тэр төсвөөс олгож байгаа татаас төсвийн орлогын хувийг бодох юм бол 23 онд харин бүр 2.7 хувь болж буурч байгаа юм. Тэгэхээр энэ нөхцөл байдалтай уялдуулаад бид нар сангийнхаа дотоод нөөц боломж дээр бас тулгуурлаад явах юм бол бас энэ ачаалал нь бас харьцангуй менежмент хийж болох юм байна гэж үзээд мөн Сангийн яамтай бас зөвлөлдөж, тооцоогоо нийлүүлж байгаад 5 жил болгох нь боломжтой байна. Угаасаа цаашдаа энэ бид нар бүрэн хуримтлалын тогтолцоонд зорьж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ цаашдаа 5, 7 юу энэ бол онцын ач холбогдолгүй болно. Бидний

гол шинэчлэл нь хуримтлалын бүрэн тогтолцоо руу явж байна. Энэ цаг үедээ мэдээж тодорхой тооны бас ахмадуудад бас зарим тэтгэврийн тогтоолгоход бас илүү багаар тогтоогдоод байгаа нөхцөл байдал үүсээд байгаа учраас үүнийгээ бас бодолцоод бас өмнө байсан 5 руугаа бас орох нь зүйтэй юм байна лээ гэж явж байгаа юм.

П.Анужин: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Дахиад дэмжиж байгаа. Хэдэн тодорхой асуулт асууя. Энэ олон давхаргатай тэтгэврийн тогтолцоо руу явж байгаа. Тийм ээ. Тэгэхээр энэ дээр энэ хувийн тэтгэврийн тогтолцоо заавал орж ирж байгаа юм. 3 дугаар давхарга дээр нь. Тэгэхээр энэ хувийн тэтгэврийн тогтолцооны чинь эрсдэлээ яаж хаах юм бэ? Хуулиар, бид нар маш олон эрсдэлүүдийг даван туулсан. Маш олон мөнгөө алдсан. Төр хүртэл яам, НДЕГ-тайгаа хүртэл байж байгаад энэ банканд хүртэл мөнгөө алдчихаж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хувийнхан дээр иргэдийн төлж байгаа энэ шимтгэлийн эрсдэлийг энэ хуульд яаж хаахаар оруулж ирж байгаа юм бэ?

7 жилийг 5 жил болгоно гээд энэ зөв өө. Энэ яг хүмүүст хүлээлттэй байгаа. Юу гэхээр өнөөдөр тэтгэвэр амьдралд нь хүрээд байсан бол хүмүүс үүнийг нэг их сонирхохгүй. Тэтгэвэр амьдралд нь үнэхээр хүрэхээ болиод өөр орлого байхгүй байгаа учраас ингээд тогтоолгоод ирэхээр нэг нэг тэтгэвэр авагч тэр ойролцоогоор ингээд бага л юм байна лээ л дээ, 100 гаруй мянган төгрөгийн нэмэгдэл л нэмэгдэж орох юм уу. Энэ дээр яг хэдэн төгрөг нэмэгдэж орохоор тооцоолол байгаа вэ гэдгийг ажлын хэсгээс асууя.

3 сараар жилийн тэтгэвэр жил болгон 3 сараар юу тэтгэврийн нас нэмэгдэж байгаа. Энэ чинь албан юу сайн дурын үндсэн дээр биз дээ. Эс үгүй бүр юу гэдэг юм албан журмын маягтай ингээд заавал хүрэх нас ингэж болгож байгаа юу? Үүнийг бас нэг энэ дашрамд та хэдээс бас тодорхой тодруулаад асуучихъя.

Дээрээс нь энэ юу, өнгөрсөн хугацаанд энэ хуулийн цоорхой гарсан. Тодорхой хүмүүс маш богино хугацаанд маш өндөр НДШ төлөөд түүгээрээ тэтгэвэрт гарсан, ийм яг хэдэн хүн байна. Энэ чинь бас тэр нөгөө тэтгэврийн зөрөө шударга бус байдал энэ тэр дээр нэлээн бухимдал үүсгэдэг тоо шүү дээ. Үүнийг та хэд нэг тодорхой хэлээдхээч. Яг хэчнээн хүн байна? Хэд орчим төгрөгийн дундаж тэтгэвэр аваад хүмүүс энэнд бас бухимдаад байгаа юм бэ? Тэгэхээр үүнийг ийм цоорхой гаргахгүйгээр энэ хуулийн төслөө манайхан сайн бичсэн юм байгаа биз дээ гэдэг нэг ийм асуулт байна.

2 дугаарт, энэ сая ерөнхий хууль дээр тэр улсын төсвөөс татаас байдлаар бусад тэтгэвэр авагчдын НДШ-ийг нөхөн төлөлт гэдэг байдлаар малчдын НДШ дээр 48 тэрбум төгрөг гээд нэг тоо сонсчих шиг боллоо. Энэ яг ямар учиртай юмыг ярьж байна гэсэн ийм тодорхой хэдэн асуултад хариулт авъя.

П.Анужин: 1 номерын микрофонд НХХ-ын яам, Батжаргал дарга хариулна.

Б.Батжаргал: Туваан гишүүний эхний асуултад хариулъя. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуультай холбоотой асуулт асуусан. Эрсдэлийг хаах зорилгоор энэ хуулийн төсөл дээр эрсдэлийг тараан байршуулах, хяналт хийх, холбогдох заалтуудыг бүгдийг нь оруулж өгсөн байгаа. Тухайлбал бүх бүртгэлийг кастадион банкаар дамжуулж хийхээр болсон. Хувийн нэмэлт тэтгэврийн сан ч юм уу,

даатгалын компани өөрөө бүртгэлээ хийхээс гадна кастадион банк бүх өдөр тутмын бүртгэлийг хийж, хяналт тавих ийм зохицуулалтыг оруулсан байгаа.

Хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх үндсэн байгууллага бол ХОМК байхаар тусгасан. Хөрөнгө оруулалтаа тэтгэврийн сан тодорхой хэсгийг нь л өөрсдөө хийнэ. Гол гол үндсэн хөрөнгө оруулалтыг ХОМК хариуцагч хийхээр оруулсан байж байгаа. Холбогдох этгээдийн хориглолтыг бүгдийг нь оруулж өгсөн байгаа. Хөрөнгө оруулалтын менежментийн компани уучлаарай, тийм. Хөрөнгө оруулалтын менежментийн компани. Холбогдох этгээдийн хориглолтуудыг бүгдийг нь оруулж өгсөн байгаа. Энэ жишээлбэл, кастодион банк болон хөрөнгө оруулалтын менежментийн компани, хувийн тэтгэврийн сангууд хоорондоо тэр брагеин буюу хууль бус гүйлгээнүүд хийх бүх холбогдох хаалтуудыг нь бүгдийг хууль дээр хийж өгсөн байж байгаа.

Иргэдийг хамгаалах 1 зүйл байгаа нь баталгаат өгөөжийг заавал өгөхөөр хуулийн төсөлд тусгасан байгаа. Батлаад өгөөжөө өгч чадахгүй энэ үйл ажиллагааг нь зогсоохоор ингээд хуулийн төсөлд ингэж тусгаж өгсөн байгаа. Баярлалаа.

П.Анужин: Нэмэлт хариулт үлдсэн асуултын хариултыг 2 номерын микрофонд Өнөрбаяр дарга өгье.

Г.Өнөрбаяр: Туваан гишүүний асуултад хариулъя. 7-г 5 жил болсонтой холбогдуулаад бид нар бас нарийн тооцооллуудыг хийж үзэж байгаа. Энд 2 асуудал яригдана. Энэ хууль маань 2019 оноос хэрэгжиж эхэлсэн. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ хууль батлагдсан тохиолдолд нөхөн үйлчлэх юм уу гэдэг асуудал яригдана. 19 оноос хойш тогтоогдсон хүмүүсийн асуудал бас яригдана гэдгийг эхлээд хэлэх ёстой.

Жилд өөрөөр хэлбэл бид нар ингээд тооцоогоор жишээлбэл ирэх жил яг ийм нөхцөлөөр нэг 14-өөс 15000 орчим хүн энэ нөхцөлөөр тэтгэвэрт гарахаар бас байгаа. Жилд зарцуулах мөнгөн дүн бол 20 тэрбум төгрөг байгаа. 1 хүн дээр ингээд нэмэгдэх мөнгөн дүнг нь дундажлаад аваад үзэх 60-аас 70000 төгрөг байгаа. Мэдээж тухайн хүмүүсийн тийм ээ, төлсөн шимтгэл, ажилласан жилээсээ шалтгаалаад өөр өөр байгаа. Би саяынхыг бас дундаж л ярьж байгаа тоо шүү гэдгийг бас хэлэх гэсэн юм

2 дугаарт нь, тэр өндрөөр тэтгэвэр тогтоогдох болон энэ нийгмийн даатгалын санд ер нь улс зарим шийдвэрүүд бол нийгмийн даатгалын санд ихээхэн хэмжээний алдагдал бас үүсгэж байгаа. Үүнийг бас ярих ёстой. Бусад зарим улс орнууд нийгмийн даатгалын санд ингээд алдагдалд нөлөөлөл үзүүлэх буюу алдагдал үүсгэх ийм шийдвэрүүдийг нийт даатгуулагчдаас ажил олгогчдоос асуух ийм тохиолдлууд бас их байдаг. Манай улс ч гэсэн өөрөөр хэлбэл энэ гаргаж байгаа зарим шийдвэрүүд нийгмийн даатгалын санд асар их хэмжээний алдагдал үүсгэж байгаа учраас энэ асуудлыг бас ярих ёстой. Тухайлбал би 2, 3 кейс ярьж л даа. Энэ ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг 12 онд баталсан. Энэ хуулийн үйлчлэлд 608000 хүн хамрагдсан. Төлсөн шимтгэлийн хэмжээ 37.9 тэрбум төгрөг төлсөн. Энэ 608000 хүнээс одоогийн байдлаар 263000 хүн нь тэтгэврээ тогтоолгох болон тэтгэврээ өөрчлөн тогтоолгосон. Гарсан зардал нь 868 тэрбум төгрөг одоогийн байдлаар гараад явж байгаа. Цаашдаа энэ 608000 хүн бүхэлдээ бүрэн тэтгэвэр тогтоолгоод үүний алдагдал бол бас хэдэн их наядаар яригдана гэдгийг бас хэлэх ёстой.

Мөн Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийг 2015 онд баталсан. Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулиар цалин орлогоо бас буруу мэдээлж байсан гэдэг нууцын зэрэглэлээр 16000 хүн тэтгэврээ өөрчлүүлэх ийм асуудал хийгдсэн. Үүний нийгмийн даатгалын санд ямар нөлөөлөл юу алдагдал үүсгэсэн бэ гэдгийг бас хэлэх боломжгүй. Яагаад гэвэл энэ нууцтай холбоотой ийм асуудал хийгдсэн гэдгийг бас хэлье.

Харин 3 дахь нь өөрөөр хэлбэл энэ НДШ-ээ багаар төлж байгаад сүүлийн дараалсан 5 жилд нь өндрөөр огцом төлдөг ийм тохиолдлууд нийгмийн даатгалын санд шударга бус нөхцөл байдлыг үүсгэж байгаа. Сангийн дата мэдээллээс харахад жилд нэг тийм мянга орчим хүн ийм нөхцөлөөр тэтгэврээ тогтоолгож байгаа ийм асуудал бас байгаа. Тэгэхээр бид нар энэ дээр ямар хаалт хийж байгаа вэ гэхээр шинэ хуулийн зохицуулалтаар өөрөөр хэлбэл тэтгэврийн дээд доод хэмжээг зохицуулалт хийж байгаагаас доод хэмжээг сайн дураар төлж байгаа хүмүүс 7 дахин гэж хязгаарлалт хийж өгсөн байгаа гэдгийг бас хэлье.

Малчдын НДШ-тэй холбоотой асуултыг та бас сая хөндөж ярилаа. Бид нар ер нь улсын хэмжээнд нэг 200 орчим мянга малчин НДШ-д хамрагдахгүй яваад байна. Энэ малчдыг нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулахгүй бол ирээдүйд энэ хүмүүс халамжийн тэтгэврээ авагчид болно. Халамжийн тэтгэврийг улсын төсвөөс яг адилхан өгнө өө. Тэгэхээр өөрөөр хэлбэл одоо нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулж авахгүй бол цаашдаа улсын төсвөөс гарах зардал нь олон их наядаар яригдана. Тийм учраас манайхан судалгаа шинжилгээ хийгээд олон улсын жишгүүдийг тооцож үзээд малчдын нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын шимтгэлийг ... /минут дуусав/

П.Анужин: Өнөрбаяр даргын хариултыг гүйцээж хариулт авъя, 2 номерын микроныг өгье.

Г.Өнөрбаяр: Малчдын 5 жилийн хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэлийг 50 хувь төлье, 50 хувийг нь малчдаар ингээд төлүүлээд урамшууллын механизмыг бас хэрэгжүүлбэл цаашид малчид маань энэ нийгмийн даатгалын сангаас тэтгэврээ авах өөрөөр хэлбэл энэ боломжууд нь бас нээгдэж өгнө өө гэсэн ийм зохицуулалтуудаар бид нар бас хуулийн төсөл бичсэн. Үүнтэй холбоотой зардлыг бас та сая хөндөж ярилаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Асуултуудад хариулт тодорхой авлаа. Тэр 3 сар дээр нэмэгдээд явж байгаа энэ дээр яг юу гэдэг юм, сонголттойгоор юм уу, эс үгүй бол бүр албан ёсных болгочихсон юм уу. Жилд 3 сарын тэтгэврийн нас нэмэгдэж байгаа шүү дээ тийм ээ. Үүнийг нэмээд хариулаад өгөөрэй.

Дээрээс нь энэ малчдын НДШ төлөх энэ юу чинь юм бол ирээдүйд батлагдвал гэж ярьж байгаа юм байгаа биз дээ, тийм ээ. Энэ хуулиуд ороод батлагдвал гэж ярьж байна. ОК. Түүнийг ойлголоо.

1 юм нэмээд асуучихад энэ эхнэр нөхөр нь 2-улаа амьдарч байгаад тэтгэврээ авч амьдарч байгаад нэг нь нас барсан тохиолдолд нас барсан хүнийх нь тэтгэврийн хэдэн хувийг гэж хуульд тусгасан бэ? Хэдэн хувийг нэмж өгөхөөр.

П.Анужин: 2 номерын микрофонд Өнөрбаяр дарга хариулна.

Тухайн гишүүний асуултад хариулъя. Өнөрбаяр. Бид нар энэ нийгмийн даатгалын хуулийн төсөл дээр тэтгэвэрт гарах насыг хүмүүст илүү их тийм сонголттойгоор хийж өгсөн. 4 янзын сонголт байгаа. Үндсэндээ багцлаад үзвэл. Одоо ээжүүд бол хүүхдийн нөхцөлөөр бол тийм ээ, 50 насандаа тэтгэвэрт гарах энэ нөхцөл байдал хэвээрээ хадгалаа. Үүгээр ямар нэгэн зүйлийг өөрчлөөгүй.

Хэрвээ 2 дахь нь бол тухайн иргэн өөрөө хүсвэл эрэгтэй хүн 60 насандаа, эмэгтэй хүн 55 насандаа тэтгэвэрт гарах сонголт нь бас байгаа. Манай нөхцөл байдлыг ингээд судалгаа хийгээд үзэхэд даатгуулагчидтай уулзахад зарим хүмүүс илүү олон жил ажиллах хүсэлтэй байдаг бол зарим хүмүүс эрт тэтгэвэрт гарах хүсэлтэй байдаг. Тэгэхээр өөрөөр хэлбэл эрт тэтгэвэрт гарах хүсэлтэй хүмүүс нь 60, 55 насандаа гарах сонголт нь хэвээрээ байгаа. Илүү олон жил ажиллана гэж байгаа хүмүүс тийм ээ, жилд 3 сараар нэмэгдүүлээд ингээд явах боломж нь байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл 3 сараар нэмэгдүүлээд явахад ирэх 23 онд ... /минут дуусав/

П.Анужин: 2 номерын микрофоныг нэмж өгье. Хариултаа гүйцээе.

Г.Өнөрбаяр: 23 онд ингээд 3 сараар би нэмэгдүүлээд тэтгэвэртээ гаръя гээд иргэн өөрөө хүсвэл эрэгтэй хүн 61 нас 6 сар, эмэгтэй хүн 56 нас 6 сартайдаа тэтгэвэрт гарах энэ сонголт нь байгаа. Эсвэл Хөдөлмөрийн тухай хуулиараа би 65 нас хүртлээ ажиллана гэвэл тэр хүний сонголт бас байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ хууль маань тийм ээ, хүн болгонд нэг нөхцөл болзлыг тулгахгүй аль болохоор сонголтуудыг өгч байгаа учраас иргэдэд илүү таатай байх болов уу гэдгийг бас хэлье ээ гэж хэлэх гэсэн юм.

Тэтгэврийн тусгай нөхцөл дээр бас ийм юу байгаа. Өмнө нь Хамтын тэтгэврийн тухай хууль дээр маш олон төрлийн хязгаарлалт болзлууд байсныг та мэдэж байгаа. Одоо бол тэр болзлуудыг аль болохоор багасгаад өөрөөр хэлбэл тэтгэвэр нь 20 хувиар нэмэгдэхээр л ийм зохицуулалтуудыг хийж өгсөн байгаа. Түүнээс биш заавал ч үгүй 20 хувь нөгөө нэг нас барсан даатгуулагчийн 20 хувь биш, өөрийнх нь авч байгаа тэтгэвэр нь 20 хувиар нэмэгдэхээр ийм зохицуулалт л хийсэн байгаа. Анхаарал авсанд баярлалаа.

П.Анужин: Баярлалаа. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Нөгөө Ахмад настны тухай хуулийн хэрэгжилт болон Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг яг хөдөө орон нутагт ажиллаж байхад ер нь яг энэ тэтгэвэр тогтоолгох журмын талаар тэтгэвэр тогтоолгох хуулийн талаар бас маш олон асуултууд ирж байсан. Өнөрбаяр дарга өөрөө хамт явж байсан болохоор сайн мэдэж байгаа байх. Би энэ дээр нэг хэд хэдэн зүйлийг тодруулаадахъя. Тэтгэвэртээ гарчхаад хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийнхээ энэ боломжийг илүү нэмж өгөх, өөрөөр хэлэх юм бол хөдөлмөрлөх чадвартай иргэдээ ажлын байран дээр нь хадгалж үлдэх тэр тал дээр ер нь ямар боломж байдаг юм бол. Ер нь тэтгэвэртээ гарчхаад хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн тэтгэврийг нэмэх тэр зохицуулалт нь ер нь ямар томъёоллоор хэрхэн яаж явдаг юм бол оо гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм.

Нөгөө талаар нөгөө хүүхдийн тоогоороо 1.5 жилийн хугацаагаар нэг нэмдэг. Тийм ээ, 1.5 жил нэмдэг байгаа. Энэ дээр нэг гомдол ирсэн юм, сонгогчоос маань. 1 хүүхэд маань 16 нас хүрэлгүйгээр нас барчихсан. Би бас та бүхэнтэй уулзаж асууж байсан. Тийм ээ. Яг ингэсэн чинь одонгоо ч авч чаддаггүй, одонгийн мөнгөө

ч авч чаддаггүй. Одоо тэтгэврээ тогтоолгох гэхээр нөгөө 4 биш 3 хүүхэдтэй гэдгээрээ 1.5 жилээ нэмж чадахгүй байна. Үүнийг нэг хуулиар зохицуулж өгөөч. Нэгэнт би хүүхэд төрүүлсэн нь үнэн юм чинь энэ дээр зохицуулалтыг нь хийж өгөөч ээ гэдэг хүсэлтийг иргэн маань тавьж байсан юм. Үүнийг зохицуулах боломж байгаа болов уу. Үгүй болов уу.

Нөгөө талаар бид бүгдийг Батсүмбэрийн асрамжийн газар очиж ажиллахад тэтгэвэр буух гэхээр Батсүмбэрийг тойроод нөгөөдөх үр хүүхдүүд нь ирээд тэтгэврийг нь аваад явчихдаг. Яг үнэхээр тэр ижий, ааваа асарч чадахгүй өөрсдөө асрамжид аваачиж өгчхөөд тийм ээ, тэр хүүхдүүдийг хүүхдүүдэд нь тэр тэтгэврийг нь олгочихдог энэ байдлыг зогсоох, үнэхээр тэр тэтгэврээ төлсөн хөдөлмөрийн хөлсөө авч байгаа гэсэн үг шүү дээ. Тийм ээ, тэтгэвэр авч байгаа чинь. Үүнийг тэр эргээд яг үнэхээр тэр настангуудад зохицуулах, олгох тэр боломжийг ер нь яаж олгох вэ?

Нөгөөтээгүүр бид нарыг бас хилээр явж байхад асууж байсан. Үнэхээр би сэтгүүлч байхдаа ч гэсэн хил дээр ажиллаж байгаа хилийн албан хаагчдын ар гэр өөрөөр хэлэх юм бол тийм ээ, нөхрөө дагаад, эхнэрээ дагаад хилээр явж байгаа энэ хүмүүс тэтгэвэр тогтоолгох боломжгүй байдаг гэдэг ийм зүйлийг маш ихээр ярьдаг. Тэгвэл яг энэ хэл дээр болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ажиллаж байгаа алба хаагчдын ар гэрийнхний тэтгэврийн асуудлыг хэрхэн яаж зохицуулж байна вэ гэдэг дээр асуулт авъя тэгэх үү. Мэдээж хууль хэлэлцэгдээд, ажлын хэсэг дээр энэ зүйлүүд бас яригдах байх л даа.

П.Анужин: 2 номерын микрофонд Өнөрбаяр дарга хариулъя.

Г.Өнөрбаяр: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Бид нар энэ шинэ хуулийн маань бас нэг шинэлэг зохицуулалтыг сая хөндөж ярилаа. Одоо тэтгэврээ тогтоолгосон ч гэсэн ажил хөдөлмөр хийж байгаа 37000 хүн бас байгаа. Энэ хүмүүст 2 төрлийн сонголт байгаа. Одоо бол өөрөөр хэлбэл тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлөөд тэтгэврээ нэмэгдүүлэн тогтоож бас болно. Эсвэл өөрөөр хэлбэл тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй, өөрөөр хэлбэл шинэ хуулиар бид нарын энэ өргөн барьж байгаа хуулиар тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлөхгүй байж болох зохицуулалтыг нь иргэнд бас олгож өгч байгаа гэдгийг бас хэлье.

2-т, та бас тэр ээжүүдийн ажилласан жилтэй холбоотой асуудлыг хөндлөө. Одоогийн хууль дээр маань хүүхдээ 6 хүртэл настайд нь тийм ээ, өсгөн бойжуулсан гэдэг заалт бас хэвээрээ байгаа гэдгийг хэлье.

Батсүмбэрийн асрамж дээр би бас ажлын хэсэгт ороод бас ажиллаж байсан. Энэ асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүмүүс нь өөрөөр хэлбэл тийм ээ, тэтгэврийг нь авах, зарцуулах ийм боломжууд бас хуулийн төсөл дээр хэвээрээ байгаа. Харин асрамж халамжийн төвүүд дээр байгаа энэ ахмадуудын тэтгэврийн энэ зарцуулалт дээр нь хяналтыг бас сайжруулах тал дээр манай яам бас нэлээн онцгой анхаарч ажиллаж байгаа. Хүн тус бүрийн бас тэтгэврийн бүртгэлийг нь хөтлөх, түүнийг ар гэрт нь танилцуулах, өөрсдөд нь танилцуулах, тухайн асрамж халамжийн газрууд энэ дээр бас анхаарах ёстой гэдэг ийм чиглэлүүдийг манай яамнаас өгөөд бас ажиллаж байгаа гэдгээ хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Сая асуусан асуултад хангалтгүй байна гэж үзнэ. Хил дээр ажиллаж байгаа хүмүүсийн тэтгэврийг хэрхэн тогтоох вэ гээд, ар гэрийн асуудлыг асууж байна л даа. Ажиллаж байгаа гэхээс гэр бүлийн асуудлыг.

Г.Өнөрбаяр: Энэ хууль дээр нэлээн тодорхой заагаад өгчихсөн байгаа. Энэ хил дээр ажиллаж байгаа хил гааль, хууль хяналтын байгууллагууд, нэг суурин газраас нөгөө суурин газарт шилжиж ажиллаж байгаа энэ хууль хяналтын байгууллагуудын ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа хүмүүсийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс зохицуулах харилцаа бас хэвээрээ байгаа, хадгалагдаж байгаа. Мөн өөрөөр хэлбэл гадаад улс оронд бас ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар ажиллаж байгаа хүмүүсийн ар гэр, эхнэр нөхрийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах энэ зохицуулалт бас байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

П.Анужин: Жаргалмаа гишүүн тодруулъя гэж байна.

Б.Жаргалмаа: Нөгөө хүүхдийн тоогоор 1.5 жил нэмдэг гэдэг дээр хариултыг дахиад авъя. Тийм ээ. Гүйцэд авчихъя. Ер нь яах ёстой юм. Хүүхэд нь нас барчихсан тохиолдолд 1.5 жилээр тооцох, тооцохгүй гэдэг зүйлийг бас тодруулж өгөөч? 1.5-аа ямар ч байсан тодруулаадахъя.

П.Анужин: Түрүүн 6 нас гээд хариулсан тийм ээ. Тэгэхдээ ахиад тодруулаад хариулъя. 2 номерын микрофонд Өнөрбаяр дарга хариулъя.

Г.Өнөрбаяр: Хуулийн зохицуулалтаар хүүхдээ 6 хүртэл өсгөж хүмүүжүүлсэн ийм тохиолдолд өөрөө 6-аас дээш нас хүргэж өсгөж хүмүүжүүлсэн тохиолдолд улсад ажилласан жилээр ингээд тооцогдоод явж байгаа. Энэ зохицуулалт бас хэвээрээ байгаа гэдгийг хэлье.

П.Анужин: Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах тухай хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор үг хэлэх гишүүдийн нэрийг авъя. Үг хэлэх гишүүд байхгүй байна. Алга байна.

Санал хураалт явуулна. Санал хураалт явуулна.

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна.

Анхааралтай гишүүд ээ, санал хураалт явах гэж байна.

Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр УИХ-ын гишүүн Батсүхийн Саранчимэгийг томилж байна.